

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/224/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: [adiyasurenb@audit.gov.mn](mailto:adiyasurenb@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tiv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

дддб.Од. 25 № 01/178  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.БАТХҮҮ  
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” 01/359 дугаартай зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 23,238.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн 16,266.9 мянган төгрөгийн тогтоон бүртгэлд тусгасан.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хүүхдийн автобус хөтөлбөр”-ын хүрээнд ТӨАХААГ/20240102068 дугаартай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Хаштехник” ХХК шалгарч

  
416020212

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

нэг бүр нь 57,497.0 мянган төгрөгийн өртөгтэй БНХАУ-д үйлдвэрлэсэн хүүхдийн шар автобусыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Хүүхдийн шар автобусны суудлын хэмжээ нь бага ангийн сурагч суух боломжгүй жижиг, техникийн шаардлага хангахгүй, эвдрэлтэй байсан тул Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль нь бүртгэл тусгаагүй байна.

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93,0 хувиар дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>568,943,607.58</b>	<b>702,973,009.06</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>331,311,881.92</b>	<b>464,739,915.26</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>331,311,881.92</b>	<b>464,739,915.26</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>331,311,881.92</b>	<b>464,739,915.26</b>
31211	Төрийн сангийн харилцах	331,311,881.92	464,739,915.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>28,128,427.05</b>	<b>25,799,182.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>28,128,427.05</b>	<b>25,799,182.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	28,128,427.05	25,799,182.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>209,503,298.61</b>	<b>212,433,911.80</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,147,884.09</b>	<b>2,275,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	2,166,900.00	2,166,900.00
35130	Эм боох материал	1,980,984.09	108,100.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>205,355,414.52</b>	<b>210,158,911.80</b>
35410	Бичиг хэргийн материал	20,224,645.26	19,094,939.52
35420	Аж ахуйн материал	18,803,027.00	27,026,927.00
35450	Барилгын засварын материал	151,600.00	151,600.00
35460	Хүнсний материал	471,900.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,196,891,449.02</b>	<b>6,560,721,301.05</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,196,891,449.02</b>	<b>6,560,721,301.05</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,009,978,449.09</b>	<b>6,373,853,684.47</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,910,111,271.63	6,254,056,271.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(435,923,997.84)	(512,720,245.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	454,545,834.54	573,775,494.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(127,501,516.95)	(191,248,728.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	173,453,113.66	243,599,617.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,079,719.36)	(63,953,184.18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	77,721,585.00	88,723,585.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,100,845.77)	(33,273,519.94)
39217	Ном	23,752,724.18	14,894,393.58
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>186,912,999.93</b>	<b>186,867,616.58</b>
39301	Програм хангамж	440,000.00	529,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(77,000.07)	(131,383.42)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,550,000.00	186,470,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,765,835,056.60</b>	<b>7,263,694,310.11</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>239,245.05</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>239,245.05</b>	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>239,245.05</b>	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>239,245.05</b>	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	239,245.05	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,765,595,811.55</b>	<b>7,263,694,310.11</b>

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,765,595,811.55</b>	<b>7,263,694,310.11</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,572,659,707.02	2,572,579,707.02
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(35,205,240.71)</b>	<b>3,462,973,257.85</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(35,205,240.71)	(35,205,240.71)
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,498,178,498.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,228,141,345.24	1,228,141,345.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,765,835,056.60</b>	<b>7,263,694,310.11</b>

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,963,266,055.48</b>	<b>7,075,758,409.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>98,025,555.48</b>	<b>3,593,671,809.41</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>98,025,555.48</b>	<b>3,534,055,809.41</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,820,900.00	19,381,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,154,700.00	18,048,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,666,200.00	1,333,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	62,418,796.00	3,461,854,123.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	19,785,858.88	52,820,286.11
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>00.00</b>	<b>59,616,000.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	5,700,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	53,916,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,865,240,500.00</b>	<b>3,482,086,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,660,557,000.00</b>	<b>3,200,890,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,660,557,000.00	3,200,890,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>204,683,500.00</b>	<b>281,196,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,683,500.00	281,196,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,820,328,654.11</b>	<b>3,577,579,910.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,820,328,654.11</b>	<b>3,577,579,910.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,693,457,226.00</b>	<b>3,389,014,326.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,936,387,106.72</b>	<b>2,382,829,074.87</b>
210101	Үндсэн цалин	1,274,753,191.58	1,430,390,021.85
210102	Нэмэгдэл	577,369,665.14	847,779,561.62
210104	Урамшуулал	84,264,250.00	104,659,491.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>232,034,742.28</b>	<b>284,788,736.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	158,990,599.73	194,885,145.22
210202	Тэтгэмжийн даатгал	19,230,525.55	23,871,571.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,605,812.82	11,929,539.99
210204	Ажилгүйдлийн даатгал	9,006,574.08	10,820,496.16
210205	Эрүүл мэндийн даатгал	35,201,230.10	43,281,984.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>199,032,183.10</b>	<b>235,679,152.70</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,813,910.10	31,700,199.70
210302	Түлш, халаалт	176,218,273.00	203,078,953.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	900,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>54,317,663.52</b>
210401	Бичиг хэрэг	00.00	14,884,400.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	2,219,210.00
210404	Ном, хэвлэл	00.00	8,858,330.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	13,072,900.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	15,282,822.92

**Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>48,250,350.00</b>	<b>65,331,850.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	300,000.00
210502	Хоол, хүнс	48,250,350.00	65,031,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>85,500,000.00</b>
210604	Урсгал засвар	00.00	85,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>5,690,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	5,690,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,245,165.62</b>	<b>49,222,967.83</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,528,000.00	9,596,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,717,165.62	39,626,867.83
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>254,507,678.28</b>	<b>225,654,880.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,157,035.96	13,874,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,158,855.65	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	179,191,786.67	211,780,240.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>126,871,428.11</b>	<b>188,565,584.57</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>123,238,911.21</b>	<b>175,144,297.57</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	112,069,140.00	162,620,420.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,169,771.21	12,523,877.57
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,632,516.90</b>	<b>13,421,287.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,632,516.90	13,421,287.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>142,937,401.37</b>	<b>3,498,178,498.56</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>142,937,401.37</b>	<b>3,498,178,498.56</b>

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,884,042,600.00</b>	<b>3,503,558,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,802,100.00</b>	<b>21,471,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>18,802,100.00</b>	<b>21,471,400.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>18,802,100.00</b>	<b>21,471,400.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,154,700.00	18,048,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,647,400.00	3,423,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,865,240,500.00</b>	<b>3,482,086,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,660,557,000.00</b>	<b>3,200,890,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,660,557,000.00	3,200,890,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>204,683,500.00</b>	<b>281,196,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,683,500.00	281,196,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,653,921,564.85</b>	<b>3,307,051,666.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,653,921,564.85</b>	<b>3,307,051,666.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,532,736,276.74</b>	<b>3,118,957,978.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,936,113,320.08</b>	<b>2,382,848,871.76</b>
210101	Үндсэн цалин	1,274,479,404.94	1,430,409,818.74
210102	Нэмэгдэл	577,369,665.14	847,779,561.62
210104	Урамшуулал	84,264,250.00	104,659,491.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>232,034,742.28</b>	<b>284,768,936.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	158,990,599.73	194,885,145.22
210202	Тэтгэмжийн даатгал	19,230,525.55	23,851,771.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,605,812.82	11,929,539.99
210204	Ажилгүйдлийн даатгал	9,006,574.08	10,820,496.16
210205	Эрүүл мэндийн даатгал	35,201,230.10	43,281,984.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>199,032,183.10</b>	<b>233,865,013.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,813,910.10	29,886,060.00
210302	Түлш, халаалт	176,218,273.00	203,078,953.00
210303	Цэвэр, бохир ус	-	900,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>48,860,150.00</b>	<b>64,422,050.00</b>
210502	Хоол, хүнс	48,860,150.00	64,422,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>36,000,000.00</b>
210604	Урсгал засвар	-	36,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,709,565.62</b>	<b>49,462,967.83</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,528,000.00	9,596,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,181,565.62	39,866,867.83
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>89,986,315.66</b>	<b>67,590,139.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,209,415.66	54,098,739.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,776,900.00	13,491,400.00

**Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>121,185,288.11</b>	<b>188,093,687.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	117,552,771.21	174,672,400.68
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	106,383,000.00	162,148,520.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,169,771.21	12,523,880.68
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,632,516.90</b>	<b>13,421,287.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,632,516.90	13,421,287.00
213404	Хөрөнгийн	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>230,121,035.15</b>	<b>196,506,333.34</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>93,189,900.00</b>	<b>63,078,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>93,189,900.00</b>	<b>63,078,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	93,189,900.00	63,078,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	93,189,900.00	63,078,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(93,189,900.00)</b>	<b>(63,078,300.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>136,931,135.15</b>	<b>133,428,033.34</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	194,380,746.77	331,311,881.92
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	331,311,881.92	464,739,915.26

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,572,659,707.02	1,228,141,345.24	(178,142,642.08)	3,622,658,410.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,572,659,707.02</b>	<b>1,228,141,345.24</b>	<b>(178,142,642.08)</b>	<b>3,622,658,410.18</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	142,937,401.37	142,937,401.37
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,572,659,707.02</b>	<b>1,228,141,345.24</b>	<b>(35,205,240.71)</b>	<b>3,765,595,811.55</b>
<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>2,572,659,707.02</b>	<b>1,228,141,345.24</b>	<b>(35,205,240.71)</b>	<b>3,765,595,811.55</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,572,659,707.02</b>	<b>1,228,141,345.24</b>	<b>(35,205,240.71)</b>	<b>3,765,595,811.55</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(80,000.00)	-	-	(80,000.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	3,498,178,498.56	3,498,178,498.56
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,572,579,707.02</b>	<b>1,228,141,345.24</b>	<b>3,462,973,257.85</b>	<b>7,263,694,310.11</b>

**Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,866,624,800.00</b>	<b>3,490,136,713.00</b>	<b>376,488,087.00</b>	<b>90.26</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,234,383,000.00</b>	<b>3,200,890,300.00</b>	<b>33,492,700.00</b>	<b>98.96</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,234,383,000.00	3,200,890,300.00	33,492,700.00	98.96
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>281,196,300.00</b>	<b>267,775,013.00</b>	<b>13,421,287.00</b>	<b>95.23</b>
132001	Орон нутгийн төсвөөс	281,196,300.00	267,775,013.00	13,421,287.00	95.23
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>351,045,500.00</b>	<b>21,471,400.00</b>	<b>329,574,100.00</b>	<b>6.12</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,595,900.00	18,048,400.00	547,500.00	97.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,333,000.00	3,423,000.00	(2,090,000.00)	256.79
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	331,116,600.00		331,116,600.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,866,624,800.00</b>	<b>3,356,708,679.66</b>	<b>509,916,120.34</b>	<b>86.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,866,624,800.00</b>	<b>3,356,708,679.66</b>	<b>509,916,120.34</b>	<b>86.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,676,961,200.00</b>	<b>3,182,036,278.98</b>	<b>494,924,921.02</b>	<b>86.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,780,779,800.00</b>	<b>2,382,848,871.76</b>	<b>397,930,928.24</b>	<b>85.69</b>
210101	Үндсэн цалин	1,661,629,600.00	1,430,409,818.74	231,219,781.26	86.08
210102	Нэмэгдэл	1,019,055,000.00	847,779,561.62	171,275,438.38	83.19
210104	Урамшуулал	100,095,200.00	104,659,491.40	(4,564,291.40)	104.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>347,597,500.00</b>	<b>284,768,936.69</b>	<b>62,828,563.31</b>	<b>81.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	236,366,300.00	194,885,145.22	41,481,154.78	82.45
210202	Тэтгэмжийн даатгал	27,807,700.00	23,851,771.17	3,955,928.83	85.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,903,900.00	11,929,539.99	1,974,360.01	85.80
210204	Ажилгүйдлийн даатгал	13,903,900.00	10,820,496.16	3,083,403.84	77.82
210205	Эрүүл мэндийн даатгал	55,615,700.00	43,281,984.15	12,333,715.85	77.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>245,196,300.00</b>	<b>233,865,013.00</b>	<b>11,331,287.00</b>	<b>95.38</b>
210301	Гэрэл, цахилгаан	38,009,800.00	29,886,060.00	8,123,740.00	78.63
210302	Түлш, халаалт	203,079,000.00	203,078,953.00	47.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	4,107,500.00	900,000.00	3,207,500.00	21.91
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>77,244,500.00</b>	<b>64,422,050.00</b>	<b>12,822,450.00</b>	<b>83.40</b>
210502	Хоол, хүнс	77,244,500.00	64,422,050.00	12,822,450.00	83.40
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,000,000.00</b>	<b>36,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	36,000,000.00	36,000,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>57,088,900.00</b>	<b>49,462,967.83</b>	<b>7,625,932.17</b>	<b>86.64</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,596,100.00	9,596,100.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	47,492,800.00	39,866,867.83	7,625,932.17	83.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>133,054,200.00</b>	<b>130,668,439.70</b>	<b>2,385,760.30</b>	<b>98.21</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	117,121,900.00	112,227,039.70	4,894,860.30	95.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,932,300.00	18,441,400.00	(2,509,100.00)	115.75

**Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>189,663,600.00</b>	<b>174,672,400.68</b>	<b>14,991,199.32</b>	<b>92.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>189,663,600.00</b>	<b>174,672,400.68</b>	<b>14,991,199.32</b>	<b>92.10</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	176,681,300.00	162,148,520.00	14,532,780.00	91.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,982,300.00	12,523,880.68	458,419.32	96.47
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>331,311,881.92</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>464,739,915.26</b>		

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 90,817.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд хандив тусламжаар хүлээн авсан 53,680.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр бүртгэсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 300.0 мянган төгрөгийн эм боох материал, 10,880.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 10,682.9 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, 1,713.2 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 5,000.0 мянган төгрөгийн мянган урсгал засварын материалыг бусад зардалд тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 4,280.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг бусад зардлаар бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтөлөлд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 4,238.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 35,775.8 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 4,238.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3 зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

#### 2. Зардлын дансны асуудалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайланд онд 1-5 дугаар ангийн 65,755 сурагчдад өдөр ногдох нормативаар тооцоход 164,387.5 мянган төгрөгийг зарцуулахаас 162,711.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 1,676.0 мянган төгрөгийг дутуу дотуур байранд байрладаг 10,966 сурагчдад ногдох нормативаар тооцоход 67,593.9 мянган төгрөгийн зарцуулахаас 65,031.9 мянган төгрөг зарцуулж, 2,562.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан.

## Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын 1-т "ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөгөөр төгрөгөөр тогтоосугай" гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан нормативын дагуу сурагчдын үдийн болон дотуур байранд байрладаг сурагчдын хоолны түүхий эд авах зардлыг олгон давтан гаргахгүй ажиллах.

### **3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 99 ширхэг 38,966.2 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд хандив тусламжаар хүлээн авсан 53,680.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр бүртгэсэн.	1	53,680.0			1	53,680.0	1	53,680.0		
2	Санхүүгийн үр дүнгийн тайлан 300.0 мянган төгрөгийн эм боох материал, 10,880.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 10,682.9 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, 1,713.2 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 5,000.0 мянган төгрөгийн мянган урсгал засварын материалыг бусад зардалд тайлагнасан.	1	32,857.0			1	32,857.0	1	32,857.0		
3	Санхүүгийн үр дүнгийн тайланд 4,280.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг бусад зардлаар бүртгэсэн.	1	4,280.0			1	4,280.0	1	4,280.0		
		<b>3</b>	<b>90,817.0</b>			<b>3</b>	<b>90,817.0</b>	<b>3</b>	<b>90,817.0</b>		

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1							
2	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайланд онд суралцсан давхардсан 1-5 дугаар ангийн сурагчдын тоогоор 65,755 сурагчдад өдөр ногдох нормативаар тооцоход 164,387.5 мянган төгрөгийн зарцуулахаас 162,711.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 1,676.0 мянган төгрөгийг дутуу, дотуур байрны давхардсан тоогоор 10,966 сурагчдад ногдох нормативаар тооцоход 67,593.9 мянган төгрөгийн зарцуулахаас 65,031.9 мянган төгрөг зарцуулж 2,562.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан.	1	4,238.0					1	4,238.0						
3	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 99 ширхэг 38,966.2 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.	1						1							
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,238.0</b>					<b>3</b>	<b>4,238.0</b>						

Төв аймгийн Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөг/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 158 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 12 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,004,086.0 мянган төгрөгийн 18 гүйлгээ, зарлагын 132,379.8 мянган төгрөгийн 12 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 219,700.1 мянган төгрөгийн 3 гүйлгээ байршуулаагүй. Мөн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангиллын 11 сарын байршуулаагүй.	1	1,353,165.9					1	1,353,165.9
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,353,165.9</b>					<b>1</b>	<b>1,353,165.9</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант онд нийт 47,449.3 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авахдаа тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн	1	47,449.3					1	47,449.3
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>47,449.3</b>					<b>1</b>	<b>47,449.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1,400,615.2</b>					<b>2</b>	<b>1,400,615.2</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)